

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ

Хорих ял эдлүүлэх ажиллагаа

ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ОЛОН УЛСЫН ХЭМ ХЭМЖЭЭ

INTERNATIONAL STANDARDS FOR THE EXECUTION OF IMPRISONMENT



Б.Галбадрах

*Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн эрхлэгч,
доктор (Ph.D), хошууч*

Товч утга: Өгүүлэлд хорих ял эдлүүлэх ажиллагааг зохицуулсан олон улсын хэм хэмжээний ойлголт, төрөл, ангиллын талаар тайлбарласан

Түлхүүр үгс: хорих ял, хоригдол, олон улсын хэм хэмжээ, хоригдлын эрх.

Abstract: The article describes the concepts, types, and classifications of international norms that regulate prison sentences.

Keywords: imprisonment, prisoner, international standards, rights of prisoners.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тэр дундаа гэмт хэрэг үйлдсэн хүний ял эдлүүлэх ажиллагаа нь олон улсын интеграцчиллын үйл явцад улс орны бодлогын чухал чиглэлийн нэг юм. Энэ төрлийн хамтын ажиллагааны зорилго нь интеграцчиллын хүрээнд ял эдлүүлэх ажиллагааны хамгийн наад захын жишгийг тогтоосон бие даасан хэм хэмжээний тогтолцоо, институцийг бүрдүүлэхэд оршдог. Олон эрдэмтэн, судлаачид хүний эрхийг хамгаалах бүс нутгийн тогтолцоог бий болгох зорилго нь универсал буюу бүх нийтийн тогтолцоог тодорхой улс, бүс нутгийн нөхцөл байдалд дасан зохицоход агуулагддаг гэж үзсэн байдаг. Гэсэн хэдий ч нэг эдийн засгийн бүсэд соёл, түүхэн уламжлалд тулгуурлан үүсдэг бөгөөд хүний эрхийг хамгаалах бүс нутгийн тогтолцоо нь бусад орны улс төр, нийгэм, соёл болон эдийн засгийн түвшинг нэгдмэл болгох зорилготой.

Английн гүн ухаанч, социологич И.Бентамын XVIII зуунд боловсруулсан “паноптикум” буюу “бүхнийг харагч” гэх хорих байгууллагын удирдлагын тогтолцоо нь хорих ял эдлүүлэх ажиллагааны чиглэлээр олон улсын хамтын

ажиллагааны эхлэл болсон гэж үздэг бөгөөд хожим нь энэ загвараар хэд хэдэн хорих ангиуд баригдсан байдаг.

Хорих ял эдлүүлэх ажиллагаа нь Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948 он), Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт (1966 он), эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (1966 он), Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд (1955 он), Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц (1987 он), Хоригдлуудтай харьцах үндсэн зарчмууд (1990 он), Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд (Манделлын дүрмүүд (2015 он)) зэрэг баримт бичгүүд дээр тулгуурладаг.

Үндэсний хууль тогтоомжийг олон улсын баримт бичиг, стандартуудтай нийцүүлэх нь манай улсын гол зорилгын нэг юм. Гэхдээ ял эдлүүлэх системд олон улсын стандартыг хэрэгжүүлэхэд олноор ял эдлүүлэх систем болон улсын эдийн засгийн байдлыг харгалзан үзэх зайлшгүй шаардлагатай.

Олон улсын баримт бичиг болон Монгол улсын Үндсэн хуульд тусгагдсан хүний эрхүүд нь олон улсын нэгдэл, байгууллагуудаар хүлээн зөвшөөрөгдсөн, олон жилийн хугацаанд тогтсон хүний амьдралын жишиг юм.

Сүүлийн жилүүдэд манай орны эрх зүйн тогтолцоо нь олон улсын хэм хэмжээнд нийцүүлэх чиглэлээр нэлээдгүй өөрчлөлт хийгдсэн. Тэр дундаа хоригдлын эрхийг хамгаалах чиглэлээр үндэсний хууль тогтоомжийг олон улсын стандартад нийцүүлэх чиглэлээр хийгдсэн ажлууд юм.

Монгол улсын иргэний эрхийг хангах, хамгаалах нь төрийн үүрэг юм. 1992 оны Монгол Улсын Үндсэн хуульд иргэний эрх болон эрх чөлөөг хуульчилж өгсөн байдаг. Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2 дугаар хэсэгт зааснаар Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ, 3 дугаар хэсэгт Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ гэж заасан байдаг бөгөөд энэхүү зарчим нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 2.2 зүйлд Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө гэж зааснаар тусгалаа олсон байна.

Монгол улсын Үндсэн хуульд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмыг эрхэмлэн хуульчилсан нь хоригдлын амьд явах эрх, халдашгүй байдал, ял эдлүүлэх ажиллагаа зөвхөн хуулийн хүрээнд явагдах зэрэг хоригдолтой харьцах жишгийг нэвтрүүлсэн гэдгийг онцлох нь зүйтэй.

И.Л. Михеев хоригдлуудтай харьцах хүрээний олон улсын актууд нь нийгмээс тусгаарлагдан хоригдож байгаа иргэний эрхийн хязгаарлалтын хүрээг

тодорхойлсон гэмт хэргийн байдалд хяналт тавих олон улсын актуудын тогтолцооны нэг хэсэг гэж тодорхойлсон байдаг¹.

В.А. Уткин ял эдлүүлэх ажиллагаанд үндэсний хууль тогтоомжоос гадна олон улсын баримт бичгийг дагаж мөрдөх боломжтой гэж тэмдэглэсэн байдаг. Гэхдээ мэдээж тухайн улсын нэгдэн орсон олон улсын гэрээ л хамаарах юм².

Олон улсын актыг хэд хэдэн байдлаар ангилдаг байна. Жишээ нь, хоригдлын эрхийн төрлөөс хамаарч С.В. Бакин а) иргэний эрхийг; б) эдийн засгийн эрх; в) нийгмийн эрх; г) соёлын эрхийг зохицуулсан баримт бичгүүд гэж ангилсан³.

М.Л. Энтин өөр нэг ангиллыг санал болгосон байна:

- хоригдол өөрийн эрхийг эдлэх боломжоор хангасан;
- шүүхийн хамгаалалт авах боломж олгосон⁴.

П.Г. Пономарев олон улсын хэм хэмжээг өөр талаас нь мөн ангилсан байна. Жишээ нь, эрүүгийн ял эдлүүлэх системийн үйл ажиллагааны чиглэлээр: хорих ял эдлүүлэх дэглэм; хоригдлын хөдөлмөр эрхлэлт болон бэлтгэл; хоригдлын дунд явуулах хүмүүжүүлэх ажил⁵.

В.А. Бажанов, А.Я. Волков, С.И. Курганов хүний эрхийг зохицуулсан олон улсын баримт бичгийг (хоригдол мөн хамааралтай) үйлчлэх хүчин чадлаар нь: заавал дагаж мөрдөх ёстой болон зөвлөмж хэлбэрийн⁶. Тэдний үзэж байгаагаар нэгдүгээр бүлэгт төрийн эрх барих барих дээд байгууллагаар дэмжигдэж нэгдэж орсон пакт, конвенц хамаарах бөгөөд энэ нь тус улсын хувьд заавал дагаж мөрдөгдөх ёстой. Харин дараагийн бүлэгт Нэгдсэн Үндэсний байгууллагын Ерөнхий Ассамблейн баталсан баримт бичгүүд байдаг бөгөөд энэ нь заавал дагаж мөрдөх бус зөвлөмжийн шинжтэй байдаг.

Профессор В.А. Уткин хоригдлын эрх зүйн байдлыг зохицуулсан олон улсын хэм хэмжээг дараах байдлаар ангилдаг байна:

1. Хамрах хүрээгээр нь – нийтлэг болон тусгай. Нийтлэг нь тусгайлан хоригдлын эрхийн талаар баталсан баримт бичиг биш бөгөөд зөвхөн зарим

¹ Михеев И.Л. Международные стандарты защиты прав осужденных. Саратов, 2010. 37 тал.

² Уткин В.А. Международное право борьбы с преступностью: учеб. пособие. Томск, 2017. 145 тал.

³ Бакин С.В. О классификации прав человека, провозглашенных в международных соглашениях // Правоведение. 1991. №2. 42 тал.

⁴ Энтин М.Л. Международные гарантии прав человека. М., 1992. 136 тал.

⁵ Пономарев П.Г. Международно-правовые стандарты обращения с заключенными и национальные варианты их реализации. Рязань. 1994. 15 тал.

⁶ Бажанов В.А., Волков А.Я. Правовое положение осужденных. Минск, 1983. 6 тал; Курганов С.И. Уголовно-исполнительное право: учеб. пособие. М., 2004. 105-106 тал.

зүйлүүд дээр л хоригдлын талаар л дурдсан байдаг. Харин тусгай нь хорих байгууллагад хоригдож байгаа этгээдүүдийн талаар баталсан эрх зүйн актууд юм.

2. Дагаж мөрдөх хэмжээгээр нь – үндэсний тогтолцоонд заавал дагаж мөрдөх ёстой болон зөвлөмжийн шинжтэй хэм хэмжээнүүд. Заавал дагаж мөрдөх гэдэгт төрийн дээд байгууллагын дэмжсэн нэгдэн орсон олон улсын пакт, конвенц болон бусад баримт бичгүүд (жишээ нь, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц (1987 он), Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт (1966 он), Монгол улсын бусад гадаадын улсуудтай байгуулсан олон улсын гэрээ). Зөвлөмжийн шинжтэй баримт бичгүүдэд Хүний эрхийн түгээмэл тунхаг (1948 он), Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд (1955 он), Европын пенитенциар дүрмүүд (2006 он) зэрэг бусад баримт бичгүүдэд агуулагдсан хэм хэмжээнүүд хамаардаг юм. Эдгээр баримт бичгүүд хууль зүйн хувьд заавал дагаж мөрдөх шаардлагагүй хэдийн ч олон улсын холбоодоор өргөнөөр хүлээн зөвшөөрөгдсөн байдаг.

3. Үйлчлэх хүрээгээр нь (газар нутгийн) – дэлхий нийтийн болон бүс нутгийн. Эхнийх нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаар батлагдан олон улсын холбоодод түгээгддэг. Хоёр дахь бүс нутгийн олон улсын байгууллага, нэгдлүүд, холбоодоор батлагддаг.

Бидний үзэж байгаагаар хамгийн сүүлийн ангилал нь хамгийн илүүгээр, тодорхойлсон байна.

Олон улсын баримт бичгийн гол зорилго нь дэлхийн аль ч улсад хоригдлууд эрх, эрх чөлөөгөө эдлэх адил боломжоор хангагдсан нэгдсэн бодлого бүхий хуулийг бүрдүүлэх юм.

И.В. Шмаровын үзэл бодолтой санал нийлэх нь зүйтэй. Тэрээр хүний эрхийг хамгаалах, хоригдлуудтай харьцах талаар заавал дагаж мөрдөх олон улсын баримт бичигт тусгагдсан зарчмууд нь 1) олон улсын шинж чанартай бөгөөд аливаа улсад үүссэн улс төрийн, эдийн засгийн, гэмт хэргийн нөхцөл байдлын сөрөг нөлөөнд өртөлгүйгээр тогтвортой байдлыг хадгалдаг; 2) НҮБ-ын гишүүн орнуудын олон жилийн туршлагад тулгуурлан боловсруулагдсан байдаг тул үндэсний хууль тогтоомжийг боловсруулахад чиглүүлэгч болж өгдөг⁷.

Хоригдлын эрх зүйн байдлыг хөндсөн хүний эрхийн олон улсын гэрээ, хэлэлцээрүүд олон байдаг ба эдгээр баримт бичгүүд нь дэлхийн дийлэнх орны үндэсний хууль тогтоомжид нэвтрүүлэх боломжтой байдаг. Олон улсын хамтын

⁷ Шмаров И.В. Разработка уголовно-исполнительного законодательства в сфере международных соглашений о защите прав человека и документов ООН, определяющих принцип обращения с осужденными // Сов. гос-во и право. 1990. №11. 39-40 тал.

ажиллагааны байгууллагуудын үйл ажиллагааны практик үр дүн нь олон улсын актууд байдаг.

Хоригдлын эрх зүйн байдлыг зохицуулсан олон улсын актуудад дараах баримт бичгүүд хамаардаг: Хоригдлын эрх зүйн байдал нь Хүний эрхийн түгээмэл тунхаг (1948 он), Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт (1966 он), эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (1966 он), Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд (1955 он), Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц (1987 он), Хүний эрх, эрх чөлөөний европын конвенц (1950 он), Хоригдлуудтай харьцах үндсэн зарчмууд (1990 он), Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд (Манделлын дүрмүүд (2015 он)) зэрэг баримт бичгүүд юм.

Чухам эдгээр баримт бичгүүд нь хорих байгууллагад байгаа хүний эрх зүйн байдлыг үндсээр нь өөрчилж олон улсын түвшинд гаргасан байна. Гэхдээ мэдээж эдгээр баримт бичгүүдэд улс орнууд цаг хугацааны хувьд харилцан адилгүй хугацаанд нэгдсэн байдаг.

В.Н. Белик олон улсын баримт зарим талаараа нэг талыг баримталсан байдаг гэж тэмдэглэсэн байдаг. Эдгээр баримт бичгүүдэд хоригдлын эрхийг хамгаалах, хэрэгжүүлэх баталгааны талаар тусгасан байдаг⁸. Олон улсын холбоо, хамтын ажиллагааны байгууллагууд ч хоригдлуудтай хүнлэгээр харьцах, ял эдлүүлэх ажиллагаанд хүнлэг байх зарчмыг хангахаар эрмэлздэг. Үүнтэй холбогдуулан В.А. Уткин эдгээр зарчмууд нь бүх орнуудад, тэдний эдийн засгийн байдал, газар зүйн байрлал, цаг агаарын нөхцөл байдал, үндэсний соёлын болон шашны уламжлалаас үл хамааран заавал дагаж мөрдөгдөх ёстой гэж тэмдэглэсэн байдаг⁹.

Дээрх баримт бичгүүдийн хэм хэмжээнүүд нь хоригдлын эрх зүйн байдал зохицуулсан үндэсний хууль тогтоомжийг хөгжүүлэх үүрэгтэй байдаг ба хүнлэг болон хөгжлийн шинж чанартай зөвлөмжүүдийг агуулсан байдаг. Эдгээрийн мөн чанар нь хоригдлууд амьд явах, нэр хүндээ хамгаалуулах зэрэг эрхтэй байдагт оршдог юм. Тус эрхүүдийн агуулгын хувьд юуны өмнө эрүүдэн шүүх, хүч хэрэглэх, хүний нэр төрийг гутаан доромжлохыг хориглохыг хамааруулах нь зүйтэй. Гэвч хоригдлуудтай хууль бусаас харьцахыг хориглосон олон баримт бичгүүд байдаг хэдий ч тэднээс зохих байгууллагуудад өргөдөл, гомдол ирсээр байгаа юм.

⁸ Белик В.Н. Обеспечение правовой защиты осужденных к лишению свободы: автореф. дис. ... д-ра юрид. наук. Рязань, 2014. 24 тал.

⁹ Уткин В.А. Международное право борьбы с преступностью: учеб. пособие. 147 тал.

Олон улсын хэлэлцээрүүд хоригдлын эрхийн байдлыг хөндсөн байдаг бөгөөд оролцогч орнууд дагаж мөрдөх ёстой байдаг.

Хоригдол хорих ял эдэлж байгаа ч гэсэн нийгмийн бүрэн эрхт гишүүн хэвээр үлддэг ба бусад хүмүүсийн эдэлдэг эрхүүдийн дийлэнхийг эдэлдэг. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын 16 дугаар зүйлд Хүн бүр хаана ч эрх зүйн чадвартай байх эрхээ хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй гэж¹⁰. Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүдийн 61 дүгээр зүйлд Хоригдлуудтай харьцахад тэднийг нийгмээс тусгаарласан хэдий ч нийгмийн гишүүн хэвээр үлдэнэ гэдгийг тодруулах нь зүйтэй гэж заасан байдаг¹¹.

Бидний судалж байгаа сэдвийн хүрээнд олон улсын баримт бичгүүдийн хэм хэмжээг үндэсний хууль тогтоомжид нэвтрүүлэх явдал юм. Монгол Улсын Олон Улсын гэрээний тухай хуульд олон улсын хэм хэмжээг үндэсний эрх зүйн системд хэрэгжүүлэх 2 замыг заасан байдаг. Тухайлбал, 5.1 дүгээр зүйлд Олон улсын гэрээг Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал, тухайн гэрээний үндэслэл, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчимд нийцүүлэн байгуулна, 26 дугаар зүйлд Хоёр талт болон олон талт олон улсын гэрээнд тухайн гэрээний зохицуулалт болон гэрээний нөгөө тал, эсхүл бусад талтай харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулна гэсэн байна¹².

Олон улсын баримт бичгүүдийн хэм хэмжээг үндэсний хууль тогтоомжид нэвтрүүлэхэд тухайн улсын улс төр болон эдийн засгийн нөхцөл байдлаас хамааралтай. Манай орон Зөвлөлт холбоот улсын жишгээр явсан социалист лагерийн улсуудын нэг болохын хувьд эрүүгийн ял эдлүүлэх систем нь тодорхой хэмжээгээр хаалттай байсан нь олон улсын стандартыг нэвтрүүлэх шаардлага байгаагүй гэж үзэж болох юм.

Энэхүү байдал нь Монгол Улсын ардчилсан Үндсэн хууль батлагдсанаар өөрчлөгдсөн юм.

Гэхдээ Монгол Улсын ял эдлүүлэх систем нь бүрэн хэмжээнд олон улсын жишигт нийцэж, тавигдах олон улсын стандартад тавигдах шаардлагыг бүрэн хангаж байгаа гэж хэлэх боломжгүй. Оросын Холбооны Улсын эрдэмтэд бүх орнуудын эрүүгийн ял эдлүүлэх хууль тогтоомжид олон улсын стандартыг нэвтрүүлэхэд хүндрэл учруулдаг хүчин зүйлүүдийг тодорхойлсон байдаг:

¹⁰ Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт 1966 // Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтоол шийдвэрийн эмхэтгэл 2014. 15 тал.

¹¹Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд 1955 // https://www.un.org/ru/documents/decl_conv/conventions/prison.shtml

¹² Олон улсын гэрээний тухай хууль 2016 // Төрийн мэдээлэл эмхэтгэл 2017. № 02.

- Эдийн засгийн уналт болон үүнтэй холбогдсон материаллаг, санхүүгийн нөөцийн хязгаарлагдмал байдал;
- Гэмт хэргийн өсөлт, үүнийг дагаж хоригдлын тоо өсдөг;
- Сэтгэцэд нөлөөлөх болон мансууруулах бодис хэрэглэгчдийн өсөлт, БЗХӨ өвчлөгчдийн өсөлт;
- Хоригдол болон хорих байгууллагын алба хаагчдын таагүй харьцаа, эрүүгийн ял эдлүүлэх байгууллагын мэргэжлийн албаны нэр хүнд буурах¹³.

Эдгээрээс гадна үндэсний онцлогоос шалтгаалсан хүчин зүйлүүд ч байдаг бөгөөд Монгол улсад олон улсын стандартыг хэрэгжүүлэхдээ манай улсын үндэсний, түүхийн болон нийгмийн хөгжлийн онцлогийг харгалзан үзэх хэрэгтэй.

Юуны өмнө хорих ялын мөн чанар хамааралтай. Монгол улсад ч тэр Барууны улсуудад ч тэр хорих ялын шинж чанар нь хорих байгууллагын төрлөөр тодорхойлогддог. Барууны пенитенциар системд энэ нь шоронгууд байдаг. Үүнээс Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд үндэслэн гэж үзэж болно. Монгол Улсын хувьд хорих ял нь хоригдлыг нийгмээс тусгаарлаж тусгай хүмүүжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагад байлгахтай холбоотой ял юм. Монгол Улсын хорих байгууллагын төрөл нь барууныхаас ялгагдсан байсан. Хөгжлийн хувьд манай улсын хорих байгууллага нь ОХУ-ын туршлагаас суралцаж колоний системтэй байсан бөгөөд засан хүмүүжүүлэх анги, хөдөлмөрийн лагерь гэх зэрэг юм.

Колоний систем нь казармын зохион байгуулалтаар хэсэг бүлэг хоригдлуудыг хамтад нь байлгах, хүмүүжүүлэх ажлыг хөдөлмөртэй шууд холбодог. Харин шоронгийн системийн хувьд камерын зохион байгуулалттай, бүлгээр бус ганц, ганцаар хорих явдал юм.

Монгол Улсын эрүүгийн ял эдлүүлэх системд олон улсын стандартыг хэрэгжүүлэхэд ял эдлүүлэх ажиллагааны материаллаг, ахуйн нөхцөлийн өөрчлөлт, ард иргэдийн нийгэм эдийн засгийн бодит байдлыг харгалзан үзэхгүй байх боломжгүй. Хорих байгууллагын материаллаг, ахуйн нөхцөл нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцтэй зөрчилдөх ёсгүй юм.

Дээр дурдсанаас гадна манай улсын үндэсний хууль тогтоомжид олон улсын стандартыг нэвтрүүлэхэд дараах хүчин зүйлс хүндрэл учруулж байна:

¹³ Уткин В.А. Международные стандарты обращения с осужденными и проблемы их реализации. 74 тал; Зубков А.И. Уголовно-исполнительное право России: теория, законодательство, международные стандарты, отечественная практика конца XIX – начала XX века : учебник для вузов. 683 тал.

- Нийгэм, эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын төсөв, орон тооны дутагдалтай байдал, чадварлаг хүний нөөцийн дутмаг байдал.

1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглал нь хүний бүхий л эрх, эрх чөлөөг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой байдлыг тунхагласан суурь баримт бичиг юм. Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчлалгүйгээр хуулиар хамгаалуулах эрхийг тухайн баримт бичгээр тунхаглагдсан байдаг.

1966 оны Иргэний болон улс төрийн эрхийн фактын 10 дугаар зүйлд хоригдлуудтай хүнлэг байдлаар харьцахыг тунхагласан “Эрх чөлөөгөө хасуулсан бүх хүнтэй хүнлэг харьцаж, угаас заяасан нэр төрийг нь хүндэтгэнэ”¹⁴. Энэ хэм хэмээ нь шууд хэрэгжих хэлбэртэй.

Олон улсын стандартуудын нөлөөгөөр Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль тогтоомжид хоригдлын эрх зүйн байдлын үндэс, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас хамгаалсан баталгаа тусгагдсан. Монгол Улсад өрнөсөн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хоригдлуудын ял эдлэх нөхцөлийг тэдэнтэй хүнлэгээр харьцах олон улсын стандартад ойртуулсан гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Үүнийг 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн тодорхой заалтуудад дүгнэлт хийснээр харж болох юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 210 дугаар зүйлд хоригдлын эрхүүдийг тодорхой зааж өгсөн байдаг. Хоригдлууд Монгол Улсын иргэний эрхийг тодорхой хязгаарлалттайгаар эдэлдэг. Энэ нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 29 дүгээр зүйлд заасан “Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ гагцхүү бусдын эрх, эрх чөлөөг зохих ёсоор хүлээн зөвшөөрч хүндлэх, мөн ардчилсан нийгмийн ёс суртахууны шударга шаардлага, нийгмийн хэв журам, ерөнхий сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосноос өөр хязгаарлалтад өртөгдөх ёсгүй” гэсэн агуулгад нийцэж байгаа юм¹⁵.

Манай оронд нүүрлээд байгаа эдийн засгийн хүндрэлтэй байдал нь эрүүгийн ял эдлүүлэх системд оруулах хөрөнгө оруулалтыг хэмжээг буруулж хоригдлуудыг байрлуулах материаллаг, техникийн орчныг дээшлүүлэх боломжийг хязгаарлаж байгаа юм.

¹⁴ Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт 1966 // Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтоол шийдвэрийн эмхэтгэл 2014. 12 тал.

¹⁵ Хүний эрхийн түгээмэл тунхаглал 1948 // Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтоол шийдвэрийн эмхэтгэл 2014. 8 тал.

Одоогийн байдлаар Монгол Улсад эрх зүйн шинэчлэл хийгдэж байгаа ба энэхүү шинэчлэл нь эрүүгийн ял эдлүүлэх системийг ч багтаагаад байгаа юм. Гэхдээ эрүүгийн ял эдлүүлэх системийн шинэчлэлийн шаардлагыг анхааралдаа авах хэрэгтэй хэдий ч олон улсын стандартыг хэрэгжүүлэхдээ өнөөгийн нөхцөл байдал, түүхэн онцлог болон улсын гэмт хэргийн нөхцөл байдлыг харгалзан үзэх хэрэгтэй.

Хоригдлуудтай харьцах олон улсын стандартууд нь Монгол Улсын эрүүгийн ял эдлүүлэх бодлогыг боловсронгуй болгох чиглэлийг тодорхойлж өгснийг тэмдэглэх нь зүйтэй.

Эрүүгийн ял эдлүүлэх системийн шинэчлэлийн хувьд Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 193 дугаар тогтоолоор Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй болон хаалттай тогтолцоонд шилжүүлэх хөтөлбөр батлагдсан бөгөөд 2011-2018 он хүртэл хугацаанд олон улсын стандартад нийцсэн нээлттэй, хаалттай төрлийн тус бүрдээ 1500 хоригдлын багтаамжтай төвлөрсөн хорих ангийг байгуулахаар төлөвлөсөн байдаг¹⁶. Үүнээс харахад Монгол Улсын эрүүгийн ял эдлүүлэх систем нь шоронгийн системийн туршлагыг нэвтрүүлэх боловч колоний систем буюу олноор байрлуулах тогтолцооны уламжлалыг хадгалсан хэлбэртэй байх болов уу гэж төсөөлөгдөж байна.

Олон улсын стандартыг практик дээр хэрэглэхтэй холбоотой хэд хэдэн асуудлыг нэрлэж болох юм: хорих байгууллагын алба хаагчдыг хоригдлуудтай хүнлэг байдлаар харьцахад чиглүүлэн сэтгэл зүйг өөрчлөх, эрүүгийн ял эдлүүлэх системийн хаалттай байдлыг даван гарах зэрэг. Мэдээж эдгээр асуудлыг шийдвэрлэхэд эдийн засгийн болон бусад нөхцөл байдлууд бүрдсэн байх шаардлагатай.

Үүнээс гадна Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль тогтоомжид хоригдлын эрхтэй холбогдолтой олон улсын стандартыг хэрэгжүүлэхэд дараах хүчин зүйлс хүндрэл учруулж байна:

- Эрүүгийн ял эдлүүлэх системийн төсвийн хангалтгүй байдал;
- Олон улсын стандартад бүрэн нийцсэн хорих байгууллагын дутмаг байдал, хорих байгууллагуудын хот, суурин газраас алслагдмал байрлал;
- Өндөр мэргэжлийн, бэлтгэгдсэн алба хаагчдын дутмаг байдал, ажлын байрны тодорхойлолтод нийцээгүй алба хаагчид ажиллаж байгаа байдал.

¹⁶ Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлэх хөтөлбөр // <https://www.legalinfo.mn/annex/details/6205?lawid=9788>

Ял эдлүүлэх ажлын хүрэн дэх төрийн бодлогын өөрчлөлт нь төрийн болон төрийн бус байгууллагуудын анхаарлын төвд байхаас гадна нийгмийн бүхий л давхаргын анхаарлыг татсаар байна.

Мэдээж өнөөдрийн байдлаар Монгол Улсын ял эдлүүлэх систем нь олон улсын стандартад бүрэн нийцэж байна гэж хэлж болохгүй. Дэлхийн аль нэг орон өөрийн ял эдлүүлэх системийг олон улсын стандартад бүрэн нийцэж байна гэж зарлахгүй л байх. Эрүүгийн ял эдлүүлэх системийн практикт олон улсын стандартыг нэвтрүүлэх нь ганц удаагийн ажил биш бөгөөд маш олон хүчин зүйлээс хамаарсан урт хугацааны ажил юм. Хамгийн түрүүнд улсын эдийн засгийн нөхцөл байдал, хоригдлын эрхийг хангах чиглэлээр шинэчлэл хийх төрийн бодлогоос шалтгаална.

Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль тогтоомжийг хоригдлуудтай харьцах олон улсын стандартуудтай харьцуулан үзэхэд манай улсын хууль тогтоомж хоригдлын түр хугацааны уулзалт, захидал харилцаа, хорих байгууллагын алба хаагч, эрх бүхий албан тушаалтны зүгээс хүнлэг харьцах, эсхүл хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжилж харьцахгүй байхыг шаардах, хорих ангийн захиргаагаар дамжуулан өөрт холбогдох асуудлаар өргөдөл, гомдол гаргах, өдөр тутмын сонин, сэтгүүл захиалах зэрэг хүрээний агуулгаар олон улсын стандартад бүрэн нийцэж байгааг онцлох нь зөв юм.

Иймд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хоригдлын эрх зүйг байдлыг тодорхойлсон зүйл байгаа нь эрүүгийн ял эдлүүлэх бодлогын хүнлэг байдал, хорих байгууллагын практикийг олон улсын стандартад нийцүүлэхэд ойр байгаа нь харагдаж байна.

Монгол Улсын эрүүгийн ял эдлүүлэх систем нь үе шаттайгаар барууны ял эдлүүлэх системд шилжиж байгааг онцлох нь зүйтэй. Гэвч эрүүгийн ял эдлүүлэх системд олон улсын стандартыг нэвтрүүлэхэд Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан үзэхгүй байх боломжгүй. Учир нь барууны систем нь хоригдлуудыг тусад нь нэг нэгээр нь байрлуулахыг шаарддаг бөгөөд энэ нь илүү үнэтэй ажиллагаа юм. Монгол Улсын эрүүгийн ял эдлүүлэх системийн өмнө дийлэнх хорих ангиудыг шоронгийн хэлбэрт шилжүүлэх маш хүнд даалгавар байгаа бөгөөд энэ маш их хугацааг шаардах юм.

---o0o---